

АЗИ-НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТЛОН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЖ, БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

2005 оны 11-р сарын 2-ны өдөр байгуулсан Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт Оролцогч талууд (цаашид “Оролцогч улс орнууд” гэх):

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (цаашид “АНДХХ” гэх)-ийн гарал үүслийн дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор гарал үүслийг нотлох гэрчилгээ олгох, баталгаажуулах болон холбогдох бусад захиргааны асуудлыг шийдэх үйл ажиллагааны журмыг боловсруулах талаар дараах зүйлсийг харилцан тохиролцов.

1 дүгээр зүйл: Эрх бүхий байгууллагууд

(1) Гарал үүслийн гэрчилгээг барааг экспортолж байгаа Оролцогч улс орны Засгийн газраас томилсон эрх бүхий байгууллага / байгууллагууд (цаашид “Эрх бүхий байгууллагууд” гэх) олгоно.

(2) Оролцогч улс орон бүр өөрсдийн холбогдох олгох эрх бүхий байгууллагын нэр, хаягийг бусад Оролцогч улс орнуудад мэдэгдэж, гарал үүслийн гэрчилгээг баталсан албан ёсны тамганы загварыг хүргүүлнэ. Дээрх мэдээлэл болон загварт аливаа өөрчлөлт орсон бол бусад Оролцогч улс орнуудад цаг тухайд нь нэн даруй мэдэгдэнэ.

2 дугаар зүйл: Өргөдөл

(1) Хөнгөлөлтөд хамрах болзлыг хангасан бүтээгдэхүүнийг экспортлогч ба /эсвэл үйлдвэрлэгч нь экспортлохоос өмнө тухайн бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах буюу бүртгүүлэхийг хүсч, холбогдох эрх бүхий байгууллагад бичгээр (гараар эсвэл цахим хэлбэрээр) өргөдөл гаргана. Баталгаажуулалт болон бүртгэлийн үр дүнг үе үе, эсвэл шаардлагатай тохиолдолд хянан үзэх ёстой бөгөөд үүнийг экспортлох гэж байгаа холбогдох бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах нотлох баримт болгон хүлээн авна. Шинж чанараар нь гарал үүслийг нь хялбархан баталгаажуулах боломжтой бүтээгдэхүүний хувьд экспортоор гаргахаас өмнөх баталгаажуулалтыг шаардахгүй байж болно.

(2) Хөнгөлөлтөд хамрах нөхцөлөөр экспортлох бүтээгдэхүүний ёс журмын ажиллагааг хэрэгжүүлэх үед экспортлогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарал үүслийн гэрчилгээ олгохыг хүсч бичгээр (гараар эсвэл цахим хэлбэрээр) олгох эрх бүхий байгууллагад өргөдөл гаргаж, экспортлох бүтээгдэхүүн нь гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлага хангасан болохыг нотлох зохих баримт бичгийн хамт холбогдох журмын дагуу бөглөсөн гарал үүслийн гэрчилгээг хүргүүлнэ.

(3) Олгох эрх бүхий байгууллагууд гарал үүслийн гэрчилгээ авах өргөдлийг баталгаажуулахдаа тухайн бараа нь АНДХХ -ийн гарал үүслийн дүрэм болон энэхүү дүрэмд нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд өргөдөл гаргагчаас аливаа дагалдах баримт бичгийг шаардах эрхтэй.

(4) Олгох эрх бүхий байгууллагууд гарал үүслийн гэрчилгээ авах өргөдөл бүрийг нарийвчлан шалгаж, дараах зүйлст нийцэж байгаа эсэхийг тогтооно:

(a) өргөдөл, гарал үүслийн гэрчилгээг зохих журмын дагуу бөглөж, экспортлогч эсвэл гарын үсэг зурах эрх бүхий этгээд гарын үсэг зурсан эсвэл цахим хэлбэрээр ирүүлсэн;

(b) барааны гарал үүсэл нь АНДХХ -ийн гарал үүслийн дүрэмд нийцсэн байх;

(c) гарал үүслийн гэрчилгээн дээрх бусад мэдэгдэл/оруулсан бичилт нь дагалдах нотлох баримттай тохирсон байх;

(d) барааны тарифын ангилал, тодорхойлолт, барааны хэмжээ, жин, тэмдэг, баглаа боодлын тоо, багцын тоо, төрөл нь экспортлох бараатай тохирч байх.

3 дугаар зүйл: Гарал үүслийн гэрчилгээ

(1) Гарал үүслийн гэрчилгээ нь англи хэл дээр хэвлэгдсэн АНДХХ -ийн II Хавсралтад заасан загвар бичвэрийн дагуу ISO A4 хэмжээтэй цаасан дээр хийгдсэн байна.

(2) Гарал үүслийн гэрчилгээ нь нэг эх хувь, олгох эрх бүхий байгууллагад хадгалагдах нэг хувь эсвэл хуулбараас бүрдэнэ. Гарал үүслийн гэрчилгээний өнгийг бараа экспортлох Оролцогч улс орон бүр тодорхойлж, бусад Оролцогч улс орон, Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

(3) Гарал үүслийн гэрчилгээ бүр олгосон газар тус бүрээс тусад нь олгосон үл давтагдах дугаартай байна.

(4) Эх хувийг экспортлогч барааг импортлох боомт эсвэл газар дахь Гаалийн байгууллагад хүргүүлэхээр импортлогч руу хүргүүлнэ.

4 дүгээр зүйл: Гарал үүслийн гэрчилгээ олгох

(1) Оролцогч улс орны гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагууд барааг экспортлох үед, эсвэл экспортлох бүтээгдэхүүн АНДХХ-ийн гарал үүслийн дүрмийн дагуу Оролцогч улс орны гарал үүсэлтэй гэж тооцогдох боломжтой бол ачуулсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гарал үүслийн гэрчилгээг гараар эсвэл цахим

хэлбэрээр олгоно. Гарал үүслийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

(2) Гарал үүслийн гэрчилгээн дээрх зүйлсийг арилгах, дарж бичихийг хориглоно. Ашиглагдаагүй хоосон зайг дараа нь нэмж юм бичихээс урьдчилан сэргийлэх үүднээс хэрээс тавина.

(3) АНДХХ -ийн II Хавсралтын Дүрмийн 2, 3 эсвэл 4-ийн дагуу экспортлогч Оролцогч улс орны эрх бүхий байгууллага гарал үүслийн гэрчилгээний 8-р хүснэгтэд холбогдох дүрэм журам, бүс нутгийн гарал үүслийн агуулагдах хувийг зааж өгнө.

(4) Гарал үүслийн гэрчилгээ хулгайлагдсан, алдагдаж гээгдсэн, устгагдсан тохиолдолд экспортлогч эх хувийг баталгаажуулсан жинхэнэ хуулбарыг авахын тулд гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагад бичгээр хүсэлт гаргаж болно. Хуулбарыг гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагын баримтад хадгалагдсан холбогдох баримт бичгийг үндэслэн хийнэ. Энэхүү хуулбар нь “БАТАЛГААЖСАН ЖИНХЭНЭ ХУВИЛБАР” гэсэн үгийг болон гарал үүслийн гэрчилгээний эх хувийг гаргасан огнооны хамтаар 3 -р хүснэгтэд бичсэн байвал зохино. Гарал үүслийн гэрчилгээний баталгаажсан жинхэнэ хуулбарыг гарал үүслийн гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд олгоно.

5 дугаар зүйл: Гарал үүслийн гэрчилгээг үзүүлэх

(1) Гарал үүслийн гэрчилгээний эх хувийг холбогдох бүтээгдэхүүнийг импортоор нэвтрүүлэх үед хөнгөлөлттэй нөхцөлд хамрагдахын тулд Гаалийн байгууллагад үзүүлнэ.

(2) Гарал үүслийн гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд уг барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад хүргүүлнэ.

(3) Гарал үүслийн гэрчилгээг хүчин төгөлдөр байх хугацаа нь дууссаны дараа бараа импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох гаалийн байгууллагад хүргүүлсэн тохиолдолд тийнхүү хугацааг дагаж мөрдөөгүй нь экспортлогч хянаж чадахааргүй *давагдашгүй хүчин зүйл* буюу бусад тооцохоос өөр аргагүй шалтгаанаас үүдэлтэй тохиолдолд уг гэрчилгээг хүлээн авч болно.

(4) Бараа бүтээгдэхүүнийг гарал үүслийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө импортолсон бол барааг импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох гаалийн байгууллага бүх тохиолдолд уг гарал үүслийн гэрчилгээг хүлээн авч болно.

(5) Бүтээгдэхүүний гарал үүсэл нь эргэлзээгүй бөгөөд гарал үүслийн гэрчилгээнд оруулсан мэдэгдэл болон барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн

байгууллагад барааг импортлохын тулд ёс журмын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ирүүлсэн баримт бичгийн хооронд ялимгүй зөрүү илэрсэн тохиолдолд гарал үүслийн гэрчилгээ нь тухайн бараа бүтээгдэхүүнтэй яг үнэндээ таарч байгаа бол гарал үүслийн гэрчилгээг хүчингүй болгохгүй.

6 дугаар зүйл: Гарал үүслийг баталгаажуулах¹

(1) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны Гаалийн байгууллага нь барааг экспортолж байгаа Оролцогч улс орны эрх бүхий байгууллагад баримт бичиг жинхэнэ эсэх, холбогдох бараа бүтээгдэхүүний гарал үүслийн статус үнэн зөв эсэх талаар ямар нэг эргэлзэх зүйл байгаа тохиолдолд өмнө нэвтрүүлсэн барааны тухайд түүвэр шалгалт хийлгэх хүсэлт гаргаж болно.

(2) Хүсэлтэд холбогдох гарал үүслийн гэрчилгээг хавсаргасан байх ёстой бөгөөд хүсэлтийн шалтгаан болон дурдсан гарал үүслийн гэрчилгээнд заасан мэдээлэл буруу байж болзошгүйг харуулсан нэмэлт мэдээллийг хүсэлтэд тодорхой зааж өгнө.

(3) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллага баталгаажуулалтын үр дүнг хүлээх зуураа хөнгөлөлтөд хамрагдах нөхцөлийг түдгэлзүүлж болно. Гэсэн хэдий ч импортын хориг, хязгаарлалтад хамаарахгүй, луйвар хийсэн гэх сэжиг байхгүй тохиолдолд л шаардлагатай гэж үзсэн захиргааны арга хэмжээний дагуу импортлогчид барааг нь олгож болно.

(4) Баталгаажуулах хүсэлтийг хүлээн авсан гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага нь хүсэлтэд шуурхай хандаж, хүсэлтийг хүлээн авснаас хойш гурван (3) сарын дотор хариу өгөх ёстой. Асуудлыг бодитойгоор авч үзэх, холбогдох бараа бүтээгдэхүүн нь тухайн орны гарал үүсэлтэй эсэхийг тодорхойлох зэрэг ажлыг багтаасан баталгаажуулалтын үйл ажиллагааг дуусгаж, үр дүнг зургаан (6) сарын дотор олгох эрх бүхий байгууллагад хүргүүлэх ёстой. Баталгаажуулах үйл ажиллагаа хийгдэж байх үед дэд хэсэг (3)-ыг мөрдөнө. Хүсэлт гаргаснаас хойш дөрвөн (4) сарын дотор барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад хариу ирүүлээгүй тохиолдолд гаалийн байгууллага хөнгөлөлттэй нөхцөл олгох тухай нэхэмжлэлээс татгалзаж болно. Ирүүлсэн хариу нь баримт бичгийн жинхэнэ эсэх эсвэл барааны гарал үүслийг баталгаажуулахад хангалттай мэдээлэл агуулаагүй тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагууд асуудлыг гурван (3) сарын дотор хоёр тал зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл: Бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага

¹ БНСУ-ын хувьд гарал үүслийг баталгаажуулах зорилго бүхий "Олгох эрх бүхий байгууллага" гэсэн нэр томъёо нь Гаалийн байгууллагад хамаарна.

(1) Гарал үүслийн гэрчилгээ авах өргөдөл болон ийм өргөдөлтэй холбоотой бүх баримт бичгийг гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагууд олгосон өдрөөс хойш хоёроос доошгүй жилийн хугацаанд хадгална.

(2) Гарал үүслийн гэрчилгээний үнэн зөв байдалтай холбоотой мэдээллийг бараа импортолж байгаа Оролцогч улс орны хүсэлтээр ирүүлнэ.

(3) Оролцогч улс орнуудын хооронд дамжуулсан аливаа мэдээллийг нууцын зэрэгтэйд тооцох тул зөвхөн гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулахад ашиглана.

8 дугаар зүйл: Тусгай кейсүүд

Оролцогч улс орны тогтоосон боомт руу экспортолж буй бүтээгдэхүүнийг бүгдийнх нь эсвэл зарим хэсгийн очих газрыг өөрчлөх тохиолдолд бараа импортолж байгаа Оролцогч улс оронд ирэхээс өмнө буюу ирсний дараа нь дараах дүрмийг баримтална.

(1) Бараа бүтээгдэхүүнийг тэдгээрийг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад аль хэдийн ирүүлсэн бол импортлогчийн бичгээр гаргасан өргөдлийн дагуу гарал үүслийн гэрчилгээг дээрх байгууллагууд бараа бүтээгдэхүүнийг бүгдийг нь эсвэл зарим хэсгийнх нь хувьд баталгаажуулах бөгөөд эх хувийг нь импортлогчид буцааж өгнө.

(2) Гарал үүслийн гэрчилгээнд заасны дагуу барааг импортолж байгаа Оролцогч улс орон руу шууд тээвэрлэх явцад очих газар өөрчлөгдсөн бол экспортлогч бараа бүтээгдэхүүнийг нь эсвэл зарим хэсгийг хамарсан шинэ гарал үүслийн гэрчилгээ олгуулахаар бичгээр өргөдөл гаргаж, өмнө олгосон гарал үүслийн гэрчилгээг хавсаргана.

9 дүгээр зүйл: Шууд тээвэрлэх явцад дагалдах баримт бичиг

АНДХХ -ийн II хавсралтын 5 (b) дүрмийн дагуу Оролцогч улс орнуудын гаднах бусад нутаг дэвсгэрээр барааг тээвэрлэж байгаа тохиолдолд барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад дараах баримт бичгийг ирүүлнэ:

(1) барааг экспортолж байгаа Оролцогч улс оронд гаргасан ачаа тээврийн баримт бичиг;

(2) барааг экспортолж байгаа Оролцогч улс орны гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээ;

(3) холбогдох бараанд хамаарах арилжааны нэхэмжлэхийн эх хувь; болон

(4) АНДХХ -ийн II Хавсралтын 5 (b) дүрэмд нийцэж байгааг нотлох баримт бичиг

10 дугаар зүйл: Оролцогч улс орнуудын хамтын ажиллагаа

(1) Гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой луйвар хийсэн гэж сэжиглэж байгаа тохиолдолд холбогдох Оролцогч улс орнуудын эрх бүхий байгууллагууд тухайн хүмүүст арга хэмжээ авах чиглэлээр хамтран ажиллаж, луйврын эсрэг дотоодын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

(2) Гарал үүслийг тодорхойлох, барааны ангилал, бараа бүтээгдэхүүн болон бусад асуудлаар аливаа маргаан гарсан тохиолдолд барааг импортолж байгаа болон экспортолж байгаа Оролцогч улс орнуудын холбогдох эрх бүхий байгууллагууд маргааныг шийдвэрлэх зорилгоор харилцан зөвлөлдөх ба үр дүнг бусад Оролцогч улс орнуудад мэдэгдэнэ.

(3) Оролцогч улс орон бүр АНДХХ -ийн гарал үүслийн дүрмийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбоо баригч эсвэл холбоо баригч нарыг томилно.

11 дүгээр зүйл: Үзэсгэлэнгийн зорилго

(1) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны засгийн газрын холбогдох байгууллагуудын шаардлагыг дараах байдлаар хангаж байгаа бол Оролцогч нэг улс орноос Оролцогч нөгөө улс оронд үзэсгэлэнд тавихаар илгээсэн бөгөөд үзэсгэлэнгийн үеэр эсвэл дараа нь зарж борлуулсан бүтээгдэхүүнүүд нь АНДХХ -ийн гарал үүслийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд АНДХХ -д заасны дагуу тарифын хөнгөлөлтийг эдэлнэ:

(а) экспортлогч холбогдох бүтээгдэхүүнийг тэдгээрийг экспортолж байгаа Оролцогч улс орны нутаг дэвсгэрээс үзэсгэлэн гарч буй импортолж байгаа Оролцогч улс орон руу илгээж, тэнд үзүүлэхээр байрлуулсан;

(б) экспортлогч бараагаа зарж борлуулсан эсвэл импортолж байгаа Оролцогч улс оронд ачаа хүлээн авагчид шилжүүлсэн; болон

(в) бараа бүтээгдэхүүнийг үзэсгэлэнгийн үеэр эсвэл тэр даруйд нь барааг үзэсгэлэнд илгээсэн байдлаар нь тэдгээрийг импортолж байгаа Оролцогч улс оронд зарж борлуулсан.

(2) Дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гарал үүслийн гэрчилгээг барааг импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох төрийн байгууллагад гаргах ёстой.

(3) 1 дэх дэд хэсэг нь аливаа үйл явдлын үеэр бараа бүтээгдэхүүн нь гаалийн хяналтад байх ёстой үзэсгэлэн, яармаг эсвэл ижил төстэй шоу, үзүүлэн зэрэгт хамаарна.